



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 85

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах, хөрөнгөд үнэлгээ тогтоож худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 10,000,000 /арван сая/ төгрөгийн балансын үнэтэй, 3,333,333 /гурван сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 89-37 ДУА улсын дугаартай UAZ 39629 маркийн фургон автомашиныг акталж, данснаас хасах, 1,000,000 /нэг сая/ төгрөгийн балансын үнэтэй 1,000,000 /нэг сая/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 44-14 ДУА улсын дугаартай HONDA Сара маркийн автомашины худалдах доод үнийг 1,000,000 /нэг сая/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн), Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Т.Оюунтунгалаг) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх.

2.2 Актлах хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж, акталснаас гарсан сэлбэг, материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, хаягдал төмрийг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д тушаах.

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3 Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ




Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
85 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвийн актлах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалт ад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Микробус	UAZ 39629	ДУА	89-37	2006	2007-01-05	70406108	УМЗ-414	2445	203824	10,000,000	6,666,667	3,333,333
Хөрөнгийн дүн											10,000,000 /арван сая/ төгрөг		

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
85 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвийн худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сер и	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Суудал	HONDA Cара	ДУА	44-14	1998	2008-05-01	GA410404 19	P2A-1	1500	113359	1,000,000	-	1,000,000
Хөрөнгийн дүн											1,000,000 /нэг сая/ төгрөг		1,000,000 /нэг сая/ төгрөг